



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**10**  
АНГИ

# МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

**Санамж:**

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 22 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

## **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

### **Дархлал**

Дархан цаазтай газар нутаг бий болгосноороо монголчууд дэлхийд бараг л анхдагч санаа сэдсэн үндэстний тоонд орохоор билээ. Гэвч эхлээд хүнийг дархалдаг байснаа бид өөрсдөө ч мартаж орхижээ. Хүнийг дархалдаг байсны хувьд монголчууд бараг л дэлхийд ганцаараа гэгдэхэд тийм ч их дэгсдэхгүй биз. Харин эх хэл маань тэр ойлголтыг «дархлан» хадгалсаар» байна. «Дайснаа дарж дархан цолыг олж» гэсэн баатарлаг туульсын мөр хараахан мартагдаагүй байна. Гагцхүү эр хүнд олддог байсан тэрхүү дархлал нь хүн төрөлхтний сэтгэлгээний маш өвөрмөц үзэгдэл юм. Хувь хүнийг дархалж байсан монголчууд одоо үед ард түмнээ, бүхэл үндэстнээ дархлах төрийн бодлого гаргах цаг болжээ. Монголын ард түмнийг дархлалтай болгох учир холбогдол юу вэ?

ДОХ буюу Дархлал хомсдолын олдмол хам шинж өвчнөөс одоо бүх дэлхий айж байна. Харин монголчуудад оюуны дархлал хомсдолын өвчин өнөөдөр юу юунаас аюултай заналхийлж эхэллээ.

Тэгтэл гай газар дороос гэх шиг монгол хүний эрүүл мэндийн дархлал нь бас хомсдох аюулд тулж ирэв. Яралзсан цагаан шүдтэй, тас хар үстэй, улаа бутарсан хацартай, нүдэндээ цогтой, цээж нь ханхар, хөл нь богинохон монгол эрс зөвхөн хөдөө талын бөглүү хязгаарт цөөхөн үлдэв. Хар үс нь шарлаж, цагаан шүд нь хөхөрч, богино шилбэ нь сунаж, хүрэн бор царай нь цайрч зэвхийрсэн эрчүүд хотуудын гудамжаар элбэгшив.

...Хилчин хөвгүүн хөхөө өвлийн хүйтэнд, хөр цасны зузаанд хилийн манаанд зогсож харийн нутгаас шувуу нисэн ирэхийг ч алдахгүй нүд цавчихгүй ширтэн, өвдөг чичрэхгүй бат зогсож байх тэр цагт засгийн ордонд аль нэгэн бодлогогүй түшмэдийн халамцуугаар үзэглэсэн гэрээ хэлэлцээр ч юм уу тохиролцоогоор мөнөөхөн хилчин хүүгийн зогсож буй газар аль хэдийнээ айлын мэдэлд шилжчихсэн байх болзошгүй цаг үе ирсэн биш биз ээ гэж эргэцүүлэн бодох шаардлага байна.

«Миний нутгийн газраас бурхан гуйсан ч бүү өг» гэдэг дархлалтай байсан монголчууд тэр дархлалаа гээн гээсээр байна. Өнөө үед НҮБ-ын бүрэн эрхт гишүүн улсын нутагт цэрэглэн халдаж таслан авах гэдэг бараг бүтэшгүй зүйл. Харин арга башир хэрэглэн гэрт нь орж ядахдаа зүүн баруун хаяанд нь болж өгвөл хоймор нь сууж авбал «одоо минийх боллоо» гэж дуулж болох хувилбар л «их ирээдүйтэйд» тооцогдож байгаа бололтой юм.

Аравдугаар зуунаас монголчуудын хийморь дахин бадарч хүннүгийн үеийнхээ цог золбоог үзүүлж дэлхийн тэн хагасаас илүүг нь эзэлсэн том өргөө байгуулж явсан үедээ шөрмөс сайтай эрс, шандас сайтай хүлгээрээ гайхуулж байсан бол хорьдугаар зуунд дөхөж очихын цагт үндэстний маань хүч бүрэн тарамдан суларч үгүй болохын аюултай шууд тулгарсан бүлгээ.

«Ядууг баян

Өнчнийг өнөр» болгох гэдэг дөрвөн үг бол монгол үндэстний өнөөгийн байдалд өгөх иж бүрэн хөтөч төдийгүй монголын ард түмнийг бүхэлд нь «дархлах» гол томъёо юм. Сэтгэл санааны хувьд ч, эрүүл мэндийн хувьд ч дархлал хомсдолын хам шинж илрээд байгаа өнөө үед ядуугаасаа болж «бие, хэл, сэтгэлийн» гурван цоорхойгоо нөхөх чадвар, чадамж манайханд дутаж байгааг оношилж мэдээгүй нөхөр ч алга, тааж тандаагүй дайсан ч алга, бүгд л мэдэрч байгаа билээ.

Хүн ардаа түүнд өртөгдөхгүй «дархлаатай» болгох төрийн бодлого л хэрэгтэй. Тэр бодлого төрийн авдарт, түмний цээжинд байх ёстой. Дээр дурдсан бүхэнд «дархлал» хомсдож байгааг л хүн бүрд ухамсарлуулан гэгээрүүлэх, иргэний болон ардын ухаарал төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх түлхүүр- дархлал дутаж байна.

<<Монголын ард түмнийг иж дархлалтай болгон дархлах>> үзэл баримтлал боловсруулж үндэстэнд маань нүүрлэж буй бие сэтгэлийн дархлал хомсдолын хам шинжийг иж бүрнээр сэргийлэн улсаа ч «дархан манай улс» ард түмнээ ч; «дархан манай ард түмэн» гэж тунхаглахад хэрэгтэй.

Л.Түдэв

### **Монгол хэлний даалгаврууд**

1. “Монголчуудад оюуны дархлал хомсдол юу юунаас аюултай байна” гэсэн санаа гарсан хэсгийн толгой өгүүлбэр аль вэ?
  - A. ДОХ өвчнөөс дэлхий айж байна.
  - B. Монгол хүний эрүүл мэндийн дархлал хомсдох аюул ирэв.
  - C. «Миний нутгийн газраас бурхан гуйсан ч бүү өг» гэдэг дархлалтай байсан монголчууд тэр дархлалаа гээн гээсээр байна.
  - D. <<Монголын ард түмнийг иж дархлалтай болгон дархлах>> үзэл баримтлал боловсруулав.
2. Эсээнд дэвшүүлсэн асуудлыг олоорой.
  - A. «Миний нутгийн газраас бурхан гуйсан ч бүү өг» гэдэг дархлалтай байсан монголчууд тэр дархлалаа гээн гээсээр байна.
  - B. Хүн ардаа түүнд өртөгдөхгүй «дархлаатай» болгох төрийн бодлого л хэрэгтэй.
  - C. Монголчууд одоо үед ард түмнээ, бүхэл үндэстнээ дархлах төрийн бодлого гаргах цаг болжээ.
  - D. Тэр бодлого төрийн авдарт, түмний цээжинд байх ёстой.
3. Эсээний гол санааг илэрхийлсэн өгүүлбэр аль вэ?
  - A. «Миний нутгийн газраас бурхан гуйсан ч бүү өг» гэдэг дархлалтай байсан монголчууд тэр дархлалаа гээн гээсээр байна.
  - B. <<Монголын ард түмнийг иж дархлалтай болгон дархлах>> үзэл баримтлал боловсруулж бие сэтгэлийн дархлал хомсдолын хам шинжийг иж бүрнээр сэргийлэн улсаа ч ард түмнээ ч «дархан манай ард түмэн» гэж тунхаглахад хэрэгтэй.
  - C. Аравдугаар зуунаас монголчуудын хийморь дахин бадарч хүннүгийн үеийнхээ цог золбоог үзүүлж дэлхийн тэн хагасаас илүүг нь эзэлсэн том өргөө байгуулж явсан.
  - D. Харин монголчуудад дээгүүр тусдаг оюуны дархлал хомсдолын өвчин өнөөдөр юу юунаас аюултай заналхийлж эхэллээ.
4. “Тэгтэл гай газар дороос гэх шиг монгол хүний эрүүл мэндийн дархлал нь бас хомсдох аюулд тулж ирэв” гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
  - A. Яралзсан цагаан шүдтэй, тас хар үстэй, улаа бутарсан хацартай, нүдэндээ цогтой, цээж нь ханхар, хөл нь богинохон монгол эрс зөвхөн хөдөө талын бөглүү хязгаарт цөөхөн үлдэв.
  - B. Өнөө үед НҮБ-ын бүрэн эрхт гишүүн улсын нутагт цэрэглэн халдаж таслан авах гэдэг бараг бүтэшгүй зүйл.
  - C. Аравдугаар зуунаас монголчуудын хийморь дахин бадарч хүннүгийн үеийнхээ цог золбоог үзүүлж дэлхийн тэн хагасаас илүүг нь эзэлсэн.
  - D. «Дархлал» хомсдож байгааг л хүн бүрд ухамсарлуулан гэгээрүүлэх, иргэний болон ардын ухаарал төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх түлхүүр-дархлал дутаж байна.

5. “Аравдугаар зуунаас монголчуудын хийморь дахин бадарч Хүннүгийн үеийнхээ цог золбоог үзүүлж дэлхийн тэн хагасаас илүүг нь эзэлсэн” гэсэн баримтын хэлбэрийг зөв тодорхойлсныг олоорой?
- A. Зохиолч эшлэл баримт ашигласан учраас эшилсэн баримт
  - B. Аравдугаар зуун, Хүннүгийн үе гэх зэрэг тодорхой цаг үеийг харуулсан тул тоон баримт
  - C. Аравдугаар зуунаас монголчуудын хийморь дахин бадарсан гэж таамагласан баримт
  - D. Дэлхийн тэн хагасаас илүүг нь эзэлсэн түүхтэй учир бодит баримт
6. Сурагч Мөнхөө, Тунгаа хоёр “Ядуугаасаа болж «бие, хэл, сэтгэлийн» гурван цоорхойгоо нөхөх чадвар, чадамж манайханд дутаж байна” гэсэн зохиолчийн үзэл бодол дээр санал зөрөлдөв. Учир нь Мөнхөө зохиолчтой санал нэг байсан бол Тунгаа эргэлзсэн. Тэгвэл дараах үзэл бодлуудаас аль нь Тунгаагийнх вэ?
- A. Сэтгэл санааны хувьд ч, эрүүл мэндийн хувьд ч дархлал хомсдолын хам шинж илрээд байгаа учир.
  - B. Бие, хэл, сэтгэлийн гурван цоорхойгоо нөхөх чадвар, чадамж манайханд дутаж байна
  - C. Бие, хэл, сэтгэлийн гурван цоорхойгоо нөхөх чадвар, чадамж манайханд дутаагүй.
  - D. Сэтгэл санааны хувьд ч, эрүүл мэндийн хувьд ч дархлал хомсдолын хам шинж илрээгүй.
7. 2-р цогцолборын “Харин ” гэсэн холбоосны үүргийг тодорхойлоорой.
- A. Лавшруулан холбох
  - B. Эсрэгцүүлэн холбох
  - C. Угсруулан холбох
  - D. Онцлон холбох
8. “Яралзсан цагаан шүдтэй, тас хар үстэй, улаа бутарсан хацартай, нүдэндээ цогтой, цээж нь ханхар, хөл нь богинохон монгол эрс зөвхөн хөдөө талын бөглүү хязгаарт цөөхөн үлдэв” гэсэн өгүүлбэр дэх таслалын үүргийг тодорхойлоорой.
- A. Дүрийн зан төрхийг дүрслэн дүрслэн тоочих
  - B. Дүрийн гадаад төрхийг дүрслэн тоочих
  - C. Монгол эрсийн нутаглан буй газар орныг тоочих
  - D. Монгол хүний бие эрхтний өнгийг тоочих
9. Тэгтэл **гай газар дороос** гэдэг шиг монгол хүний эрүүл мэндийн дархлал нь бас хомсдох аюулд тулж ирэв. Өгүүлбэрийн онцолсон хэлцийг солин найруулахад аль нь тохиромжтой вэ?
- A. өвчин хэлж ирэхгүй хийсэж ирдэг
  - B. сэтгэлээс гай сэжгээс барцад
  - C. сэжгээр өвдөж, сүжгээр эдгэх
  - D. өргүй бол баян, өвчингүй бол жаргал
10. “Гай газар дороос гэж монгол хүний эрүүл мэндийн дархлал **бас** хомсдох аюулд тулж ирэв” гэсэн өгүүлбэрийн “бас” холбох үгийг солин найруулахад хамгийн оновчтой нь аль вэ?.
- A. харин
  - B. гэвч
  - C. мөн
  - D. ба

**Үндэсний бичгийн даалгаврүүд**

11. Үндэсний бичгээр бичсэн өгүүлбэрийг зөв уншаарай.

ᠲᠦᠰᠡᠮᠡᠯᠠ ᠬᠦᠨᠢ ᠶᠡᠰᠡᠨ ᠡᠷᠳᠡᠮᠢᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠷ  
ᠲᠦᠪᠰᠢᠨ ᠰᠡᠲᠭᠡᠯ ᠨᠡᠨ ᠡᠷᠬᠡᠮ.  
ᠲᠦᠰᠡᠮᠡᠯᠠ ᠬᠦᠨᠢ ᠶᠡᠰᠡᠨ ᠡᠷᠳᠡᠮᠢᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠷ  
ᠲᠦᠪᠰᠢᠨ ᠰᠡᠲᠭᠡᠯ ᠨᠡᠨ ᠡᠷᠬᠡᠮ.  
ᠲᠦᠰᠡᠮᠡᠯᠠ ᠬᠦᠨᠢ ᠶᠡᠰᠡᠨ ᠡᠷᠳᠡᠮᠢᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠷ  
ᠲᠦᠪᠰᠢᠨ ᠰᠡᠲᠭᠡᠯ ᠨᠡᠨ ᠡᠷᠬᠡᠮ.  
ᠲᠦᠰᠡᠮᠡᠯᠠ ᠬᠦᠨᠢ ᠶᠡᠰᠡᠨ ᠡᠷᠳᠡᠮᠢᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠷ  
ᠲᠦᠪᠰᠢᠨ ᠰᠡᠲᠭᠡᠯ ᠨᠡᠨ ᠡᠷᠬᠡᠮ.

- A. Түшмэл хүний есөн эрдмийн дотор Төвшин сэтгэл нэн эрхэм.
- B. Түшмэл хүний ёс эрдмийн доор Төвшин сэтгэл нэн эрхэм.
- C. Түшмэл хүний ёсон эрдмийн дотор Төвшин сэтгэл нэг эрхэм.
- D. Түшмэл хүний есөн эрдмийн дотор Төвшин сэтгэл нэг эрхэм.

12. Хувилах үсгээр төгссөн хэсгийг олоорой.

A.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

B.

ᠭᠣᠨᠠᠨᠠᠭ

C.

ᠨᠠᠭᠤᠰ

D.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

13. Хувилгагч толгойт бүлэг нөхцөлийг олоорой.

A.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

B.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

C.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

D.

ᠰᠡᠨᠰᠢᠨ

14. “ᠠᠨᠠᠭᠤᠰ” хэмээх өвөрмөц бичлэгтэй үгийг кириллээр зөв хөрвүүлснийг олоорой.

- A. ямагт
- B. илд
- C. ялалт
- D. илт

15. “ᠠᠨᠠᠭᠤᠰ” гэсэн үгийн “-дуи” бүтээвэр нь.....

- үгүй гэсэн үгийн утгыг илтгэнэ
- -аад гэсэн нөхцөлийн утгыг илтгэнэ
- -д гэсэн нөхцөлийн утгыг илтгэнэ
- аандаа гэсэн үгийн утгыг илтгэнэ

**Уран зохиолын даалгаврүүд**

16. Монголын нууц товчоо зохиол нь “монголчуудын ахуйн соёлыг тусгасан” болохыг аль хэсгээр баталж болох вэ?

- A. Тэмүжинд Сорхон-шар "Намайг үнсээр хийсгэн алдав, чи. Одоо даруй эх ба дүү нарын зүг яв" гэж, ам цагаан эрмэг хулагч гүүг унуулж, тэлээ хургыг чанаж, хөхүүр ба нэг нум, хоёр сум өгч, эмээл ба хэтгүйгээр явуулав.
- B. Би сайн нөхөр чамайг мунгинаж явна гэж тус болохоор ханилж явсан билээ. Би олз эрсэнгүй.
- C. Би Наху баяны ганц хөвүүн тул миний эцгийн зөөсөн хураасан хөрөнгө надад элбэг хүрнэ"
- D. Наху баян өгүүлрүүн: "Хоёр залуус үүнээс хойш сайхан нөхөрлө, бие биеэ битгий орхи" гэв. Тэндээс Тэмүжин мордож гурван өдөр гурван шөнө яваад Сэнгүр горхинд байгаа гэртээ хүрэв.

**17. МНТ-ны**

“...Боорчи, Мухулай нар

Булт биднээс

Их тусалж

Илүү зүтгэсэн үү?

Тэмдэглэн соёрхоход

Тэднээс би

Дутуу тусалж

Ядуу зүтгэсэн үү?...” гэсэн хэсэгт тухайн дүрийн сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?

A. гэмшиж харууссан

B. гомдож тунирхсан

C. зэмлэж эгдүүцсэн

D. тунирхан дургүйцсэн

**18. Тайчуудын Таргудай Хирилтуг, шадар нөхдөө дагуулж, "Хурганы үс гуужив, төлөгний бие төлжив" хэмээн Тэмүжинийг барихаар хөөдөг. Тэмүжин тэднээс зугтаж яваад аргагүйн эрхэнд баригдахын өмнө ямар үйл явдал болдог вэ?**

A. “Бүгд ес хоног хоолгүй байж “Энэ мэт нэргүй үхэхээр гаръя” гээд зам бөглөн унасан гэрийн чинээ цагаан чулууг тойрон гарахад саад болох модыг сумч хутгаараа огтлоод морио хөтөлж гарав”

B. “Тэмүжинийг хойд унгаст хар (мухлаг) тэргэнд агуулж, “Амьтан хүнд бүү хэл” гэж Хадаан нэртэй охин дүүгээр асруулав”

C. “Тэмүжин ах дүү нар мордож, үүрээр бурхан халдуны зүг одов. Хуагчин эмгэн, Бөртэ үжнийг нууя гэж бүхээгтэй тэргэнд оруулав”

D. Түүнийг тэрэгнээс чирч гаргаад Хуагчин хоёуланг сундалж Тэмүжиний хойноос өвсний налархайгаар мөшгөж, Бурхан халдун өөд гарав.

**19. МНТ зохиолд Таян хаан Жамухаас "Тэр сүрэг хонинд орж хотонд нь хүртэл хөөж яваа чоно мэт довтлогч ямар хүмүүс вэ?" гэж асуухад Жамуха юу гэж хэлдэг вэ?**

A. "Тэмүжин анд минь, дөрвөн нохойг хүний махаар тэжээж гинжнээс уяж байдаг билээ. Одоо манай харуулыг хөөж ирэгчид тэр дөрвөн нохой биз.

B. Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй, жижиг тугалын бэлчих газраас гарч үзээгүй

C. Адил зэргийн дайсанд араа үзүүлж яваагүй, алалдах тулалдах өдөрт агтаа ухруулж үзээгүй

D. Харгана зорчлоор хатгалдаж нуур байрлалаар байлдаж, цүүц хатгалдаанаар цөмөрч тулъя”

**20. МНТ-ны “Хөхөчосын сургаал” шүлгийн**

“Шүүдрээр унд хийж

Шүлсээр хоол хийж

Салхиар унаа хийж

Саадгаар нөхөр хийж явдаг” гэсэн хэсэгт уран дүрслэлийн ямар арга байна вэ?

A. Хэтрүүлэл

B. Егөөдөл

C. Ихэсгэл

D. Багасгал

**Санамж:**

- ✓ Хоёрдугаар хэсгийн даалгавар сонгох биш, харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт будаж тэмдэглээрэй.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ****2.1 Хүснэгт дэх мэдээлэл баримт уу, үзэл бодол уу?**

	Мэдээлэл нь	Баримт	Үзэл бодол
a.	Монгол бичгийг төрийн бичиг болгох сэргээн хэрэглэх бүх нийтээрээ эзэмших тухай бүхий л шатанд ихэд ярьж хэлэлцсээр байгаа боловч үр дүн нь ханалттай бус байна.	1	2
b.	Монгол бичиг нийт 29 үсэгтэй бөгөөд үүнээс гадаад үгийг тэмдэглэх 9 үсэгтэй.	1	2
c.	Энэ нь монгол бичгийнхээ сайн мууд байгаа биш үндэстний сэтгэлгээ, идэвх, эх оронч үзэл, өөрийгөө хамгаалах зөн зэрэг зүйлээс хамааралтай юм.	1	2
d.	Монгол бичгийг сэргээн мандуулж 2025 оноос хос бичигтэн болохоор хуульчлан тогтоосон байна.	1	2
e.	МЭӨ 3 дугаар зууныг хүртэл Палестин орчимд хэлэлцэгдэж байгаад зөвхөн бичгийн хэл болж үлдсэн боловч 19 дүгээр зуунаас ахин амьд ярианы хэл болон сэргэсэн түүхтэй.	1	2

**2.2. Дүрслэх ур маягаар бүтсэн өгүүлбэрүүдийг ур маягтай нь зөв харгалзуулаарай.**

- |    |   |   |           |
|----|---|---|-----------|
| a. | Хаяан дахь ишиг хурга майлалдан, хөгжим нийлүүлнэ   | 1 | Амьдчилал |
| b. | Өсөх насандаа Ононы мөсөн дээр шагалцан наадаж, өдгөө идэр цагтаа бүх Монголын хувь заяанд холбогдсон чи бид хоёр нэг нарны дор багтахгүй ээ.           | 2 | Адилтгал  |
| c. | Орогшин хул морь нь үзүүр нь хэрмийн чих шиг урт шар хялгастай, жаахан доошлоод бор, улаан, ягаавтар холилдон ууссан үзэмжит урт чихээ солбиулна.       | 3 | Тойруулал |
| d. | Үнэхээр түмэн багц хүжийг шатаавч үнэр нь үл дарагдам.  |   |           |
| e. | Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён салхи гунигтайхан хэсүүчилж, нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн эрин зуунд илгээнэ. | 4 | Хэтрүүлэл |